

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН 2 ДУГААР БАГ ДЭНЖ ГУДАМЖНЫ 12-Р ХЭСЭГТ БАЙРЛАХ 109-Р БАЙРНЫ АШИГЛАХГҮЙ БАЙГАА ХЭСГИЙГ БУУЛГАХ АЖИЛ

А. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

В. Захиалагчийн хяналтын зардлыг барилга угсралтын ажлын төсөөвт өртгийн дүнгийн 2%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

Г. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

1. Ерөнхий шаардлага

- Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм 1-р хэсэг, 2-р хэсэг – Ерөнхий шаардлага БНБД 12.03.04, БНБД 12.04.06 стандартыг тус тус мөрдөж ажиллана.
- Ажлын талбайн зохион байгуулалт болон ажилтнуудын аюулгүй байдлыг бүрэн хангасан байх ба ажилтнууд хамгаалах хэрэгслээр бүрэн хамгаалагдсан байна.
- Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм дүрэм, стандартыг мөрдөж ажиллаагүйгээс гарах эрсдэлийг гүйцэтгэгч компани бүрэн хариуцна.
- Гүйцэтгэгч ёе шатны ажлын үед захиалагчийг дуудаж далд ажлын акт үйлдэж баталгаажуулна.
- Буулгалтын ажлын явцад барилгын ашиглагддаг хэсгийн үргэлжилсэн ханын уулзвар хэсэгт цууралт үүсэх, эvdэгдэж гэмтэхээс сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай.
- Ажлын явцад гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаях ба ажил дууссаны дараа талбайг цэвэрлэж хүлээлгэн өгнө.
- Гүйцэтгэгч нь ашиглагч болон захиалагч, захиалагчийн хяналтын төлөөлөлтэй нягт уялдан ажиллах шаардлагатай.
- Ажлыг гүйцэтгэх үед нийтийн эзэмшилийн талбайн тохижилт, зогсоол, камер, цахилгааны, интернетийн кабель утсыг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлан захиалагч байгууллагад хүлээлгэн өгнө.


Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

- Буулгалтын ажлыг техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
- Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
- Буулгалтын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
- Буулгалтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

5. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
6. Гүйцэтгэгч нь буулгалтын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.
7. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу буулгалтын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
8. Унийн саналд Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "IY" 81-95-12-г мөрдлөг болгоно.
9. Авто тээврийн зардлыг ЗТЯ-ны 2013.07.10-ны өдрийн 162 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.
10. Унийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:

ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН
АЛБАНЫ ДАРГА



Т.ОТГОНБАЯР

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:

ХОТЫН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЧ, БАРИЛГА
БАЙГУУЛАМЖ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

 С.ГЭРЭЛЦЭЦЭГ

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

ХУЧИЛТ БУУЛГАХ АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Өндөр хүчин чадалтай нураах алхаар төмөр бетон хучилтыг задлаж буулгах	м3	5.32
2	Төмөр дамнуууг салгаж буулгах	м	63.5

ХАНА, ХАМАР ХАНА БУУЛГАХ АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Өндөр хүчин чадалтай нураах алхаар тоосгон хана буулгах	м3	159.15
2	Өндөр хүчин чадалтай нураах алхаар тоосгон хамар хана буулгах	м3	115
3	Чулуун ханын өргийг задалж буулгах	1м3	174.02
4	Өндөр хүчин чадалтай нураах алхаар төмөр бетон багана буулгах	м3	6.12

СУУРЬ БУУЛГАХ АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Өндөр хүчин чадалтай нураах алхаар бетон суурийг задлаж буулгах	м3	22.48
2	Өндөр хүчин чадалтай нураах алхаар хамар ханын суурийг задлаж буулгах	м3	7.62

ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хөрсөнд гараар ухах	м3	205.74
2	Барилгын хог ялгаж овоолох ба автомашинд экскаватораар ачиж зөөх	м3	489.71
3	Барилгын талбайг 140 морины хүчтэй бульдозероор тэгшлэх	м2	617.22